

ЭВИДЕНСЕ АУДИТ ХХК-д

Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-ийн 2017 оны санхүүгийн

тайланд өгсөн зөвлөмжийн биелэлт

1. Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх, авлага, өр төлбөрийг барагдуулах талаар зохион байгуулалттай арга хэмжээ авч ажиллах

- Тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.10 дахь заалт, ТӨБЗГ-ын 2016 оны 151 тоот тогтоолыг үндэслэн "Геологийн төв лаборатори" ТӨҮГ-ын захирлын 2018 оны 4-р сарын 24-ны А/20 тоот тушаалаар байгууллагын авлага барагдуулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулж ажиллаж эхлээд байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар тооцоо нийлж баталгаажуулаагүй байсан 316 харилцагчтай холбоотой 363,1 сая төгрөгийн авлагаас 2018 оны эхний хагас жилийн байдлаар 22 харилцагчтай 69,4 сая төгрөгийн тооцоог нийлж баталгаажуулсан. 2-р улирлын байдлаар өмнөх оны үлдэгдлээс 239,9 сая төгрөгийн авлага барагдуулсан ба 2018 онд гэрээт ажлын болон төсвийн хөрөнгөөр санхүүжигдэн хийгдэж буй геологи хайгуулын компаниудын шинжилгээний ажлын авлага өссөн ч 2018 оны жилийн эцсийн авлагаас 51 харилцагчийн 1017,7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаад байна. Үүнээс Тэргүүн ресурс ХХК-ийн 40,1 сая төгрөгийг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газарт шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлт гаргаж гүйцэтгэлийн шатандаа явж байна.
- 2017 оны жилийн эцсээр 98 харилцагчтай 99,8 сая төгрөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй байснаас 11 харилцагчийн 37,2 сая төгрөгийн тооцоог нийлж баталгаажуулсан ба цаашид авлага, өглөгөө тухай бүр нь барагдуулах, тооцоо нийлж баталгаажуулах ажлаа эрчимжүүлэн ажилласнаар 2018 оны жилийн эцэст 14 бэлтгэн нийлүүлэгчийн 115,0 сая төгрөгийн тооцоог нийлж баталгаажууллаа.

2. Тайлан тэнцэлдээ татварын өр төлбөрөө үнэн зөвөөр тусгах, залруулах

НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна. 15.2-т НББ-ийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсний дагуу НӨАТ-ын тооцооны зөрүүг гаргасан ба тайлант хугацаандаа залруулсан болно.

ЕРӨНХИЙ НЯ-БО  Д.МӨНХТУЯА